



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 06/06

Улаан-уул

Г Ухуулах хуудас болон зурагт самбарыг Г
байрлуулах байршлыг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 6 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Орон нутгийн Хурлын нөхөн сонгууль явуулахтай холбогдуулан ухуулах хуудас болон зурагт самбарыг нийтийн эзэмшлийн гудамж, талбай олон нийтийн газарт байрлуулах байршлыг нэр дэвшигчдийн эрх тэгш байдлыг хангах зарчмаар нэр дэвшигчдийн харьяа намын байр, штабын гадна, Бийрийн-Уулзвар 5 дугаар багт ажиллах ухуулах байрны гадна байрлуулахыг зөвшөөрсүгэй.

2. Шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНГОР



Ёсчилсон 2022 оны 03 сарын 10 ны өдөр